



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/41

Чойр


### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.МҮОНТ-ийн Түүх, уламжлал, өв соёлын нэвтрүүлгийн редакцтай хамтран зохион байгуулах танин мэдэхүйн “Дөрвөн бэрх” нэвтрүүлэгт манай аймгийг төлөөлж ахмадууд оролцох болсон тул тус арга хэмжээнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээнд шаардагдах 1,652,000 (нэг сая зургаан зуун тавин хоёр мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2024  
оны .01. дүгээр сарын .11. -  
ны өдрийн А.1/11 дугаар  
захирамжийн хавсралт

**“ДӨРВӨН БЭРХ” НЭВТРҮҮЛЭГТ ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Нэрс	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Айраг	л	30	8000	240.000
2	Ааруул /хэвийн/	ш	15	10.000	150.000
3	Ааруул /тавгийн/	кг	3	30.000	90.000
5	Шатахуун /3 машин/	л	150	2480	372.000
	Хоол	Хүн	15	20.000	300.000
	Хөтлөгчийн төлбөр	Хүн	1	500.000	500.000
Нийт дүн					1.652.000